

**ТЕХНОЛОГИ, ИННОВАЦЫН ХЭЛТСИЙН 2025 ОНЫ ЖИЛИЙН  
ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН**

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв /сая/	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
1	2	3	4	5	6	7	8
Зорилт 1. Ус цаг уур, орчны шинжилгээний салбарын технологийн судалгааг хийж ажлын чиглэлийг тогтоох, төлөвлөх, технологийн хөгжүүлэлтийн удирдамж, төсөл, хөтөлбөрийг боловсруулах, батлуулах, технологийн туршилт зүгшрүүлэлтийн ажлын хэрэгжилтийг хангах, бусад хэлтэс, харьяа байгууллагатай хамтран ажиллах							
1	<b>Гүйцэтгэлийн зорилт 1:</b> Ус, цаг уур, орчны шинжилгээний салбарын технологи, инновацийн шинэчлэл, цаг уурын өгөгдлийг боловсруулах, загварчлах системүүдийг хөгжүүлэх, дэвшилтэт программ хангамж нэвтрүүлэх, үүлэн технологи болон их өгөгдлийг боловсруулалтыг программ хангамж талаас зөвлөх, туслах,	Улсын төсөв Гадаад тусламж	Нэвтрүүлсэн программ хангамжийн тоо	0	3-4	Ус цаг уур, орчны шинжилгээний салбарын технологи, инновацийн шинэчлэл, цаг уурын өгөгдлийг боловсруулах, загварчлах системүүдийг хөгжүүлэх зорилтын хүрээнд 2025 онд дараах гол гол программ хангамжыг хөгжүүлж үйлдвэрлэлд нэвтрүүлэв. Үүнд: 1. Himawari-8/9 хиймэл дагуулын мэдээллийг татан авч боловсруулах программ хангамж. 2. Урьдчилсан мэдээг илүү нарийвчлалтай, хэрэглэгчдэд ойлгомжтой байдлаар хүргэх зорилгоор ирээдүйн 3 хоногийн 3 цаг тутмын урьдчилсан мэдээ бичих веб суурьтай программ хангамж. 3. Байгаль орчин, хэмжил зүйн төв лабораторид D-LAB цахим бүртгэлийг программ хангамжийг нэвтрүүлсэн. 4. Цаг уурын автомат станцын шөнийн хугацааны /23, 02, 05 цагийн / мэдээг	100

						<p>автоматаар хүний оролцоогүй коодлож, урьдчилан мэдээлэх шуурхай үйл ажиллагаанд ашиглах, олон улсын мэдээ солилцоонд гаргах OWL /Overnight Weather Lookout/ буюу “Шөнийн хугацааны цаг агаарыг ажиглагч” нэртэй програм хангамжийг нэвтрүүлсэн.</p> <p>5. <a href="https://archive.weather.gov.mn">https://archive.weather.gov.mn</a> сисем дээр e-barimt хэвлэн олгох боломжийг нэмэгдүүлсэн. Мөн “Цаг агаарын тодорхойлолт”-ын хүсэлтүүдийг цахимжуулах системийн хөгжүүлэлт хийв. Хэрэглэгчийн аюулгүй байдлын хамгаалалт /Тагнуулын ерөнхий газрын зөвлөмжөөр/-ын функ нэвтрүүлж, системийн хувь хүний мэдээллийн хамгаалалтыг сайжруулсан.</p> <p>6. E-Mongolia, DDISH, Засгийн газрын цахим систем зэрэг байгууллагуудтай мэдээлэл солилцох API системийг хөгжүүлсэн.</p> <p>7. <a href="http://192.168.100.30/ums">http://192.168.100.30/ums</a> систем дээр ЦАЗН-ний дараах кодчилсон мэдээг хүлээн авч задлан боловсруулж үйлчилгээнд ашиглах NCL болон VB.NET програм хангамжийг хөгжүүлсэн.</p> <p>8. Ус, цаг уур, орчны шинжилгээний салбарын дотоод мэдээлэл солилцооны системийг нэвтрүүлсэн.</p>	
2	<p><b>Арга хэмжээ-1.1</b>          Himawari-9 үүлний зураглалыг сайжруулах ажил: Himawari-9 хиймэл дагуулаас авсан үүлний мэдээллийг маск хийж weather.gov.mn цахим хуудсанд үзүүлж байгаа системийн алгоритмыг нарийвчлан боловсруулж, илүү нарийн тооцоолол бүхий</p>	Улсын төсөв	Гүйцэтгэлийн хувиар	0	100	<p>Himawari-8/9 хиймэл дагуулын мэдээллийг татан авч боловсруулах программ хангамжийг C Shell (csh) орчинд хөгжүүлж, 192.168.100.211 IP хаягтай Linux сервер дээр автомат горимд ажиллуулан ашиглаж байна. Системийн аргачлалыг шинэчлэн сайжруулсны дүнд дараах боломжуудыг нэмэгдүүлэв: Өдөр, шөнө, мөн цастай болон цасгүй нөхцөлд үзэгдлийг илүү нарийвчлалтай ангилан тодорхойлох алгоритм боловсруулав. Үүлний маск үүсгэх функцийг нэвтрүүлж,</p>	100

	шинэ томьёоллоор сайжруулна.					өгөгдлийн боловсруулалтын нарийвчлалыг нэмэгдүүлэв. Эдгээр сайжруулалт нь хиймэл дагуулын мэдээллийг боловсруулж ашиглах үйл явцыг илүү нарийвчлалтай, найдвартай, үр ашигтай болгоход чухал хувь нэмэр оруулсан. Холбоос: <a href="https://weather.gov.mn/map">https://weather.gov.mn/map</a>	
3	<b>Арга хэмжээ-1.2</b> Цаг уурын урьдчилсан мэдээний системийг сайжруулах: Урьдчилсан мэдээг илүү нарийвчлах үүднээс ирээдүйн 3 хоногийн 3 цаг тутмын урьдчилсан мэдээ бичих веб суурьтай программ хангамжийг хөгжүүлэх.	Улсын төсөв Гадаад тусламж	Гүйцэтгэлийн хувиар	0	100	Урьдчилсан мэдээг илүү нарийвчлалтай, хэрэглэгчдэд ойлгомжтой байдлаар хүргэх зорилгоор ирээдүйн 3 хоногийн 3 цаг тутмын урьдчилсан мэдээ бичих веб суурьтай программ хангамжийг боловсруулж, дотоод хэрэглээнд нэвтрүүлээ.Энэ системийг Node.js, Next.js зэрэг орчин үеийн веб технологи ашиглан шинээр хөгжүүлж, байгууллагын дотоод серверт (192.168.100.30) суурилуулсан. Программ нь урьдчилсан мэдээг гараар бичих процессыг хөнгөвчилж, цагийн давтамжтай мэдээллийг алдаа багатай, хурдан оруулах зориулалттайгаар бүтээгдсэн. Системийг 2025 оны 9-р сараас эхлэн УМХ-ийн мэргэжилтнүүд ашиглаж эхэлсэн бөгөөд одоо өдөр бүрийн 3 цаг тутмын урьдчилсан мэдээг тус программын тусламжтайгаар бичиж, дамжуулж байна.	100
4	<b>Арга хэмжээ-1.3</b> Цаг уур, орчны шинжилгээний газрын харьяа Байгаль орчин, хэмжил зүйн төв лаборатори үйл ажиллагаанд D-LAB цахим бүртгэл, мэдээллийн системийг нэвтрүүлэх	Улсын төсөв	Гүйцэтгэлийн хувиар	0	100	Байгаль орчин, хэмжил зүйн төв лаборатори нь үйл ажиллагаандаа D-LAB цахим бүртгэл, мэдээллийн системийг амжилттай хөгжүүлж, хэрэглээнд нэвтрүүлээд байна. Уг системийг Next.js, Node.js, MySQL зэрэг орчин үеийн технологиудыг ашиглан бүтэцлэснээр хэрэглэгчдэд мэдээлэл, үйлчилгээ авах үйл явцыг илүү хурдан, найдвартай болгох нөхцөлийг бүрдүүлжээ. Системд QRau цахим төлбөрийн шийдлийг нэгтгэснээр хэрэглэгчид төлбөр	100

						<p>тооцоог онлайн хэлбэрээр шууд хийх боломжтой болсон. Хэрэглэгч өөрийн бүртгэлээр нэвтэрснээр:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Хүсэлтийн явцыг үе шаттайгаар хянах</li> <li>• Төлбөрийн нэхэмжлэл хүлээн авах</li> <li>• Төлбөрийг цахимаар төлөх зэрэг нэмэлт боломжуудыг ашиглах боломж бүрдсэн.</li> </ul> <p>Холбоос: <a href="https://lab.weather.gov.mn/login">https://lab.weather.gov.mn/login</a></p>	
5	<p><b>Арга хэмжээ-1.4.</b> Цахим засаглалыг хөгжүүлж, иргэдийг чирэгдэлгүй, шуурхай, мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх "Цаг уурын архив"-ын мэдээллийг цахим хэлбэрээр төлбөрийн бүх хэлбэрээр нээлттэй хүргэх программ хангамжийг сайжруулах.</p>	Улсын төсөв	Гүйцэтгэлийн хувиар	0	100	<p>Архив мэдээллийн сангийн систем нь 2023 онд үйлчилгээнд амжилттай нэвтэрснээс хойш хэрэглэгчийн хэрэгцээ, шаардлагын дагуу тасралтгүй сайжруулалт хийгдсээр байна. Хэрэглэгчдэд илүү хүртээмжтэй, аюулгүй, үр ашигтай үйлчилгээ үзүүлэх зорилгоор дараах шинэ боломжуудыг нэвтрүүлэв:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. e-Barimt хэвлэн олгох боломж – үйлчилгээний төлбөрийн баримтыг цахимаар хэвлэх болон хадгалах боломжийг нэмэгдүүлсэн.</li> <li>2. Хэрэглэгчийн аюулгүй байдлын хамгаалалт – Тагнуулын ерөнхий газрын зөвлөмжийн дагуу нэвтэрсэн хэрэглэгчийн мэдээллийг бүртгэн хадгалах функц нэвтрүүлж, системийн хувь хүний мэдээллийн хамгаалалтыг сайжруулсан.</li> <li>3. Цахим хуудасны дизайн болон интерфэйс шинэчлэл – фонт, зохиомж, хэрэглэгчийн интерфэйсийг шинэчилж, илүү орчин үеийн, ойлгомжтой, хэрэглэгчдэд ээлтэй болгосон.</li> </ol>	100

6	<p><b>Арга хэмжээ-1.5.</b> Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуульд нийцүүлэн 9 хувийн цомхотголтой холбоотой цаг уурын өртөө харуулд шөнийн хугацааны ажиглалтыг автоматаар коодлох, шуурхай ажиллагааг тасралтгүй, хэвийн явуулах, инновац нэвтрүүлэх</p>	Улсын төсөв	Программ хангамжийн зохиож нэвтрүүлнэ	0	Нэвтрүүлсэн байна	<p>Холбоос: <a href="https://archive.weather.gov.mn/login">https://archive.weather.gov.mn/login</a></p> <p>Цаг уурын автомат станцын мэдээг шуурхай хүлээн авдаг болсноор шөнийн хугацааны /23, 02, 05/ цагийн мэдээг автоматаар хүний оролцоогүй коодлож, урьдчилан мэдээлэх шуурхай үйл ажиллагаанд ашиглах, олон улсын мэдээ солилцоонд гаргах OWL /Overnight Weather Lookout/ буюу “Шөнийн хугацааны цаг агаарыг ажиглагч” нэртэй програм хангамжийг 2025 оны 09 дүгээр сарын 01-ны өдрөөс туршилтаар нэвтрүүлээд байна. Цаг уурын салбарын 205 цаг уурын автомат станцын 1 мин тутмын их өгөгдөл (мэдээ)-ийг хянаж, станц харуулын индекс нэмэх, цагийг тохируулах зэрэг мэдээллийн нэгдсэн санд дараах мэдээллийг хүлээн авахад бэлэн болгосон.</p> <ul style="list-style-type: none"> <li>• Tair-Агаарын температур</li> <li>• Hum-Агаарын чийг</li> <li>• Wd-Салхины зүг</li> <li>• WS -Салхины хурд</li> <li>• Pst -Даралт</li> <li>• Pslp –Д.Т Даралт</li> <li>• Ptrend –Даралтын хандлага</li> <li>• Өнгөрсөн 3 цагийн салхины дундаж их хурд</li> <li>• Өнгөрсөн 3 цагийн салхины хамгийн их хурд</li> </ul> <p>Цаг уурын мэдээ дамжуулалтын нэгдсэн системд алдааг бүртгэх цэс үүсгэж хяналтыг хийж байна. Хяналтаар илэрсэн мэдээлэлд тулгуурлан 11 дүгээр сарын 20-нд гарч байсан “хх:58-хх:00 минутын таталтыг 05 минутаар, логгерийн цагийн зөрүүг ихэсгэж программд сайжруулалт хийж одоогоор программ хангамжаас</p>	100
---	---	-------------	---------------------------------------	---	-------------------	---	-----

						шалтгаалсан алдаа бүртгэгдээгүй хэвийн ажиллаж байна.	
7	<p><b>Арга хэмжээ-1.6.</b> Цаг уурын ажиглалтын шөнийн хугацааны мэдээ дамжуулах OWL(OVERNIGHT WEATHER LOOKOUT) программ хангамжийг туршилт, зүгшрүүлэлтийн ажлыг хийж, үйлдвэрлэлд нэвтрүүлэх</p>	Улсын төсөв	Үйлдвэрлэлийн туршилт хийгдсэн байна.	0	Хийгдсэн байна.	Шөнийн хугацааны мэдээг автоматаар кодлох OWL(Overnight Weather Lookout) программаар газрын даргын A/199 тоот тушаалын дагуу 9 дүгээр сарын 01-ны өдрөөс 10 станц, 8 харуулын мэдээг, 10 дугаар сард ээлжийн амралт авсан 8 харуул, 11 сард 7 харуулын мэдээг, 12 дугаар сард 2 харуулын мэдээг оруулж өдөр тутамд АК-01 мэдээг дамжуулж, хянаж байна. Аймгуудын УЦУОШТөвүүдийн хариуцсан ЦУАС хэвийн ажиллагаа, датаны мөнгөгүй болон бусад гэмтлээс шалтгаалсан алдаа гарч байгаа хэдий ч программ хангамжаас шалтгаалсан алдаа байхгүй цаг уурын өртөө шөнийн хугацаанд хоногт 3 удаа, харуул 08,14, 20 цаг тутамд, Хэнтий аймгийн Гурванбаян, Бор-Өндөр, УБ-ын Улиастай, Хуурай мухар харуулууд хүнгүй тул өдөр тутам мэдээллийг бүрэн дамжуулан ажиллаж байна.	100
8	<p><b>Арга хэмжээ-1.7.</b> Эрт сэрэмжлүүлэх тогтолцоог бүрдүүлэх зорилгоор байгалийн гамшгийг урьдчилан мэдээлэх автомат системүүд хөгжүүлэх ажлын хүрээнд цаг уурын станц, харуулын мэдээг 1 минут тутам хүлээн авч боловсруулах, цаг уурын хиймэл дагуулын мэдээг 10 минут тутам зураглаж гаргах, эдгээр мэдээллийн ашиглан давхцуулах платформ хөгжүүлнэ.</p>	Улсын төсөв	Платформыг хөгжүүлсэн байна. Гүйцэтгэлийн хувиар	0	100	Нimawagi хиймэл дагуулын мэдээллийн сангаас татаж боловсруулсан зураглалын өгөгдлийг үйлчилгээний системд дамжуулж, AWS-ийн 10 минут тутмын мэдээлэлтэй давхцуулан харуулах боломжийг Next.js дээр хөгжүүлсэн. Энэхүү шийдэл нь <a href="http://www.weather.gov.mn">www.weather.gov.mn</a> сайтын үйлчилгээний хэсэгт ашиглагдаж байна. Хугацааны хувьд үүлний зураглал нь ойролцоогоор 10 минутын хоцрогдолтой ч маш шуурхай орж ирдэг.	100

9	<p><b>Арга хэмжээ-1.8.</b> Цахим засаглалыг хөгжүүлж, иргэдийг чирэгдэлгүй, шуурхай, мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх “Цаг агаарын тодорхойлолт”-ын хүсэлтүүдийг цахимжуулах ажлыг нэвтрүүлэх.</p>	Улсын төсөв	Үйлдвэрлэлд нэвтүүлсэн байна	0	100	<p>“Цаг агаарын тодорхойлолт”-ын хүсэлтүүдийг 4 дүгээр сараас эхлэн цахимаар хүлээн авч, төлбөрийн үйлчилгээг бүрэн цахимжуулан ажиллаж байна. Энэ хугацаанд нийт 97 хүсэлт амжилттай хүлээн авч шийдвэрлэснээр 2 сая төгрөгийн орлого төвлөрүүлээд байна.</p> <p>Үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлснээр иргэд, байгууллагуудын цаг хугацааг хэмнэх, шаардлагатай мэдээллийг илүү хурдан шуурхай авах боломж бүрдсэн бөгөөд цаасны хэрэглээг бууруулж, байгальд ээлтэй шийдэл хэрэгжүүлэх давуу талтай.</p> <p>Түүнчлэн 10 дугаар сараас эхлэн хэрэглэгчийн хэрэгцээ, шаардлагын дагуу e-Barimt хэвлэн олгох боломжийг нэвтрүүлсэн бөгөөд одоогийн байдлаар 40 гаруй e-Barimt хэвлэн олгожээ.</p> <p>Холбоос: <a href="https://archive.weather.gov.mn/login">https://archive.weather.gov.mn/login</a></p>	100
10	<p><b>Арга хэмжээ-1.9.</b> Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагаанд цахимжуулах ажлыг нэвтрүүлэх ажлыг үе шаттайгаар хийх.</p>	Улсын төсөв	Үйл ажиллагаа шуурхай, нээлттэй болно. Гүйцэтгэлийн хувиар	0	100	<p>Цаг агаарт зориудаар нөлөөлсний дараа инженерүүд мэдээллээ кодчилсон хэлбэрээр сүлжээгээр дамжуулдаг. Дамжуулсан мэдээллийг хүлээн авч задлан боловсруулж, цэгүүдийг газрын зурагт дүрслэх ажлыг NCL болон VB.NET програм хангамж ашиглан боловсруулж, үйлчилгээнд ашиглаж байна.</p> <p>Энэхүү шийдэл нь мэдээллийг автомат боловсруулж, үр дүнг газарзүйн зураг дээр нарийвчлалтай харуулах боломжийг бүрдүүлсэн.</p> <p>Дотоод сүлжээ: <a href="http://192.168.100.30/ums">http://192.168.100.30/ums</a></p>	100
11	<p><b>Арга хэмжээ-1.10.</b> Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний салбарын аюулгүй ажиллагааны заавар шинэчлэн</p>	Улсын төсөв	Заавар боловсуулагдсан байна.	0	100	<p>Газрын даргын 2025 оны 10 сарын 09-ны өдрийн А/218 тоот тушаалаар Салбарын аюулгүй ажиллагааны заавар боловсруулах ажлын хэсгийн тушаал, ажиллах удирдамж, төлөвлөгөөг боловсруулан батлуулсан.</p>	100

	боловсруулах ажлыг зохион байгуулах					Одоогоор зааврын боловсруулалтыг хянаж, 2 бүлгийг боловсруулан, ажлын хэсгийн гишүүдийн боловсруулсан хуваарьт бүлгүүдийг нэгтгэж хугацаанд нь батлуулахад бэлэн болсон. 2025.12.11-ны өдөр Харьяа байгууллагын дарга нартай хэлэлцүүлэг хийж эцсийн боловсруулалтыг хийсэн. 2026 оныг Газраас "Хөдөлмөрийн аюулгүй байдал, технологи шинэчлэлийн жил" болгож байгаатай холбогдуулан уг дүрэм, зааврыг БОУАӨСайдаар батлуулж, эмхэтгэл болгон хэвлүүлнэ. Үргэжлжүүлэн 2026 онд хийгдэнэ.	
12	<b>Арга хэмжээ-1.11.</b> Байгууллагын гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсуулж батлуулах	Улсын төсөв	Төлөвлөгөө боловсруулагдсан байна	0	100	Чингэлтэй дүүргийн Онцгой байдлын хэлтэст хүсэлт гаргаж ахмад Б.Номин-Эрдэнээс зөвлөмж авч байгууллагын гамшгаас хамгаалах төлөвлөгөөг боловсруулсан. Ус цаг уур орчны шинжилгээний газар /цамхагийн байр/-ны хувьд гал түймэр, газар хөдлөлт, халдварт өвчин дунд түвшинд, "Төв байр"-ны хувьд Газар хөдлөлт, гал түймэр их эрсдэлтэй үнэлэгдсэн тул гамшгийн эрсдэлийг бууруулах 2025-2028 он хүртэл төлөвлөгөө гарган батлуулж холбогдох албан хаагчдад хүргүүлсэн. Байгууллагын гамшгаас хамгаалах 72 хуудас бүхий тайлан боловсруулан Чингэлтэй дүүргийн Онцгой байдлын хэлтсийн орлогч дарга Б.Амандыхаар хянуулж, газрын даргаар батлуулан мөрдөн ажиллаж байна. Байгууллагын вэб хуудас <a href="https://namem.gov.mn/d/action-commission/471">https://namem.gov.mn/d/action-commission/471</a> байршуулж нийт ажилчдад танилцуулсан.	100
13	<b>Арга хэмжээ-1.12.</b> Ус, цаг уур, орчны шинжилгээний салбарын дотоод мэдээлэл	Улсын төсөв	Программ хангамж зохиогдож үйлдвэрлэлд	0	100	2025 оны 02 дугаар сараас дотоод мэдээлэл солилцооны системийг хөгжүүлэх ажлыг эхлүүлж, тавдугаар сард эхний хувилбарыг үйлдвэрлэлд амжилттай нэвтрүүлэн ашиглаж эхэлсэн.	100

	солилцооны системийг хөгжүүлэх		нэвтрүүлсэн байна			Систем нь гадаад болон дотоод гэсэн хоёр сүлжээнд зэрэг ажиллаж, гадаад сүлжээнд <a href="http://info.weather.gov.mn">http://info.weather.gov.mn</a> домэйныг байршуулан үйлчилгээнд ашиглаж байна. Мөн энэ системд зориулж архив мэдээллийн сангийн хуучин серверийг бүрэн форматлан, шинэ системийн программ хангамжийг суулган ашиглалтад оруулсан. Системийг хөгжүүлэхдээ дараах орчин үеийн технологи, програм хангамжуудын хамгийн сүүлийн хувилбарыг ашиглав. Үүнд: Next.js, Node.js, MySQL, Tailwind CSS, Ant Design (Antd) зэрэг. Энэхүү мэдээлэл солилцооны системийг нэвтрүүлснээр байгууллагын албан хаагчид цаг үеийн болон сургалт семинарын мэдээлэлийг шуурхай авах боломжтой болсон.	
14	<b>Гүйцэтгэлийн зорилт 2:</b> Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, шинэ технологи, инноваци нэвтрүүлэх, экспедицийн нийт бие бүрэлдэхүүний тусгай эрхийн сургалтыг зохион байгуулах.	Улсын төсөв, гадаад зээл тусламж	Үйл ажиллагааны хэрэгжилт /хувиар/	0	100	2025 онд улсын хэмжээнд цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааг нийт 46 экспедиц амжилттай зохион байгуулж, холбогдох дүрэм журам, аюулгүй ажиллагааны зааврыг бүрэн мөрдөн ажиллав. Үйл ажиллагааны явцад байнга мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ямар нэгэн осол, гэмтэл, зөрчилгүй, мэргэжлийн баг бүрэлдэхүүний бэлтгэл, зохион байгуулалт ажилласан. <b>Пуужингийн нөөц, зарцуулалтын байдал</b> 2024 оны жилийн эцэст улсын хэмжээнд нийт 538 ширхэг пуужингийн үлдэгдэл байсан бөгөөд 2025 оны 06 сарын 21-ний өдөр цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагаанд ашиглагдах шинэ 1150 ширхэг пуужинг БНХАУ-аас татан авч, аймгуудад хэрэгцээ шаардлагын дагуу хуваарилсан. 2025 онд улсын хэмжээнд нийт 768 ширхэг пуужин ашигласан байна.	100

					<p>Хадгалалт, тээвэрлэлтийн горим бүрэн хангагдаж, пуужингийн бүртгэл, зарцуулалтын тайлагналтыг тогтмол хянаж ажилласан.</p> <p><b>Хүний нөөцийн чадавхыг сайжруулсан байдал:</b></p> <p>- 2025 оны 04 сарын 14–15-ны өдрүүдэд цаг агаарт зориудаар нөлөөлөх, хур тунадас нэмэгдүүлэх экспедицүүдийн албан хаагчдын мэргэжлийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор “Тэсрэх материалтай харьцах ажилтан”-ы эрхийн сургалтыг зохион байгууллаа. Уг сургалтыг Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн харьяа Тэсэлгээний сургалт, судалгааны төвтэй хамтран амжилттай зохион байгуулсан бөгөөд сургалтаар тэсрэх материалын ангилал, аюулгүй ажиллагааны горим, хадгалалт, тээвэрлэлтийн шаардлага, ашиглалтын үеийн эрсдэлийн удирдлага зэрэг онол-практикийн хөтөлбөрийг багтаав. “Тэсрэх материалтай харьцах ажилтан”-ны эрхийн үнэмлэх авсан.</p> <p>- 2025 оны 09 сарын 30-ны өдөр цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааны зохион байгуулалт, арга зүй, техник-технологийн үр нөлөөг дээшлүүлэх зорилготой “Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааны үр нөлөөг сайжруулах нь” сэдэвт уулзалт, семинарыг зохион байгуулав. Семинарыг танхим болон онлайн хэлбэр зохион байгуулсан.</p> <p><b>Хамтын ажиллагаа:</b></p> <p>- Дорнод аймгийн цаг уурын төвийн даргын албан бичгээр ирүүлсэн хүсэлтийг үндэслэн хур тунадас нэмэгдүүлэх, хил дамнасан түймэр, тал хээрийн түймрийг унтраахад дэмжлэг үзүүлэх зорилгоор “Онон бороо-3” хээрийн экспедицийг</p>
--	--	--	--	--	---

						<p>шинээр байгуулж, 2025 оны 10-р сарын 01-ний өдрөөс эхлэн ажиллуулж эхлэв.</p> <p>- 2025 оны 07 сарын 02-ны өдөр нийслэлийн засаг даргын тамгын газартай Хүй 7 худаг болон Улаанбаатар хот орчимд цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааг гүйцэтгэхтэй холбоотой хамтын ажиллагааны гэрээ байгуулан ажилласан. Гэрээний дагуу ЦУОШГ-ын харьяа "Богд бороо" экспедиц болон Төв аймгийн "Зуунмод бороо" экспедицүүд хамтран ажиллаж, Улаанбаатар хот орчимд хур тунадас нэмэгдүүлэх 20 удаагийн үйл ажиллагаа зохион байгуулж ажилласан.</p> <p>-Тайландын Хаант Улсын Хааны Бороо, Хөдөө аж ахуйн агаарын тээврийн газартай "Цаг агаарт зориудаар нөлөөлөх техникийн хамтын ажиллагаа"-ны хүрээнд Тайланд улсад ашиглагддаг газрын суурин генераторыг Монгол улсад ашиглах эрхийг авсан. Мөн нэг суурин генератор босох үнийн судалгаа болон ашиглагдах түлшний үнийн судалгааг хийж, аймгийн засаг дарга нарт албан тоотоор хүргүүлж, орон нутгийн хөгжлийн төлөвлөгөө болон төсвөөр шийдвэрлүүлэн хэрэгжүүлэхээр ажилласан.</p>	
15	<p><b>Арга хэмжээ-2.1</b> Цаг агаарт зориудаар нөлөөлж, хур тунадас нэмэгдүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж, явуулах</p>	Улсын төсөв	46 экспедицийн бүрэн ажиллуулна	46	46	<p>2025 онд улсын хэмжээнд нийт 46 экспедиц цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааг төлөвлөгөөний дагуу амжилттай зохион байгуулсан. Бүх экспедицүүд нь "Цаг уур, орчны шинжилгээний заавар" ШЗ.XIV.01.01.2023-д заасан аюулгүй ажиллагааны дүрэм, журамыг чанд баримталж, технологийн болон зохион байгуулалтын бүх шаардлагыг ханган ажилласан. Экспедицүүдийн жилийн эцсийн тайлан 79.7–100%-ийн</p>	100

						гүйцэтгэлтэй гарсан нь цаг агаарт зориудаар нөлөөлөх ажлыг улсын хэмжээнд тогтвортой, үр дүнтэй хэрэгжүүлсэн. Мөн нэмэлтээр Дорнод аймгийн цаг уурын төвийн даргийн албан бичгээр ирүүлсэн хүсэлтийг үндэслэн хур тунадас нэмэгдүүлэх, хил дамнасан түймэр, тал хээрийн түймрийг унтраахад дэмжлэг үзүүлэх зорилгоор Онон бороо-3 хээрийн экспедицийг байгуулж, 2025 оны 10-р сарын 01-ний өдрөөс эхлэн ажиллуулах тушаалыг газрын даргаар батлуулан, хэрэгжилтийг ханган ажилласан.	
16	Арга хэмжээ-2.2 Цаг агаарт зориудаар нөлөөлөх борооны пуужинг БНХАУ-аас татах, аюулгүй байдлыг хангаж, орон нутгуудад хувиарлах, хүргэх	Улсын төсөв	Татан авалтын тоо	1	1	2023 оны 10 сарын 24-ны өдөр "Beijing Auxin Chemical Technology LTD" компаниас 1150 ширхэг JFJ-3 пуужин, 22 ширхэг удирдлагын төхөөрөмж нийт 200310 ам.долларын худалдан авахаар тус компанитай 23MN11EA01GCX0926-1 дугаартай гэрээ хийсэн. Тэсэрч дэлбэрэх аюултай бодис тул хилээр гаргах тусгай зөвшөөрлүүд дээр нийлүүлэгч талаас бага зэрэг удааширсан. 2025 оны эхээр пуужин хүлээн авах ажлыг шийдвэрлүүлэхэд дэмжлэг хүссэн албан бичгийг 01/211 (2025.04.16) БОУАӨЯ-нд уламжилсан. Улмаар тус яамнаас 2025.04.25-ны өдөр 01/2026 албан тоотыг БНХАУ-аас Монгол улсад суугаа элчин сайдад уламжлан 2025 оны 5 сарын 30-нд БНХАУ-ын Элчин сайдын яам болон Эрээн хотын Консулын газрын Гадаад харилцааны албатай Эрээн хотын аюултай ачаа бараа гаргадаг газрын засвар болон тээвэрлэлтийн асуудлаар холбогдон ажилласаар 6 сарын 20 өдөр пуужинг Замын-Үүд дээрээс хүлээн авсан.  Тус пуужингаас 750 ширхэг пуужинг аймгуудад ЦАЗН-ны хэрэгцээ,	100

						шаардлагын дагуу 2025 оны 6 сарын 20-ны өдөр хуваарилж газрын даргаар батлуулан хувиарын дагуу аймгууд ирж хүлээн авсан. Харин Өмнеговь, Дундговь, Архангай аймгууд нь хадгалах зориулалтын байргүй болон өмнөх жилийн пуужингийн үлдэгдэлтэй гэсэн үндэслэлээр энэ удаад татан авалт хийгээгүй бөгөөд эдгээр аймгуудад хуваарилагдсан пуужингууд ЦУОШГ-ын агуулахад стандартын дагуу хадгалсан.	
17	<b>Арга хэмжээ-2.3</b> Экспедицүүдэд аюулгүй ажиллагааны заавар зөвлөмж өгч, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах	Улсын төсөв	Заавар зөвлөмжийн тоо	1-2	2-дээш	2025 онд цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагаанд оролцсон бүх экспедицүүдийг аюулгүй ажиллагааны шаардлага, мэргэжил-арга зүйн удирдлагаар хангах ажлыг төлөвлөгөөний дагуу тасралтгүй зохион байгуулсан. "Цаг уур, орчны шинжилгээний заавар" ШЗ.XIV.01.01.2023-д заасан аюулгүй ажиллагааны заавар, зөвлөмжийг ажил эхлэхийн өмнө болон явцад тухай бүр өгч, хэрэгжилтэд хяналт тавив. Экспедиц бүр хээрийн гаралтад гарахдаа ерөнхий зохицуулагчаас 100 гаруй удаа зөвшөөрөл авч, шийдвэрүүдийг шуурхай олгож зохицуулсан. Үүссэн нөхцөл байдалд мэргэжлийн зөвлөгөө, анхааруулгыг утсаар болон "ЦУОШГ-ЦАЗН" группээр дамжуулан хүргэж, мэдээллийн урсгалыг тасралтгүй ханган ажилласан.	100
18	<b>Арга хэмжээ-2.4</b> "Богд бороо" экспедицыг шаардлагатай үед ажилуулах	Улсын төсөв	Үйл ажиллагаа явуулсан тоо	2-3	5-дээш	ЦУОШГ газрын "Богд бороо" экспедиц нийт 12 удаа цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагаа явуулсан. Үүнээс 11 удаагийн гаралт нь Улаанбаатар хотын захирагчийн ажлын албатай байгуулсан "Ажил гүйцэтгэх" гэрээний хүрээнд Монгол наадам цогцолбор, хүй долоо худаг орчмын зуншлагын байдлыг дэмжихэд чиглэгдсэн.	100


19	<p><b>Арга хэмжээ-2.5</b> ЦАЗН үйл ажиллагаанд шинэ технологи, инноваци бий болгох ажлыг зохион байгуулах</p>	Улсын төсөв	Гадаад орны хамтын ажиллагааг өргөжүүлэх	1	2-оос дээш	<p>1.Тайландын Хаант Улсын Хааны Бороо, Хөдөө аж ахуйн агаарын тээврийн газартай "Цаг агаарт зориудаар нөлөөлөх техникийн хамтын ажиллагаа"-ны хүрээнд Тайланд улсад ашиглагддаг газрын суурин генераторыг Монгол улсад ашиглах эрхийг авсан. Мөн нэг суурин генератор босох үнийн судалгаа болон ашиглагдах түлшний үнийн судалгааг хийж, аймгийн засаг дарга нарт албан тоотоор хүргүүлж, орон нутгийн хөгжлийн төлөвлөгөө болон төсвөөр шийдвэрлүүлэн хэрэгжүүлэх боломжийг эрэлхийлэн ажилласан.</p> <p>2. 2025 оны 10 сарын 10-ны өдөр Байгаль орчин, уур амьсгалын яамны М.Должинсүрэнд Арабын нэгдсэн улстай хамтран "Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааг сайжруулах нь" төслийн саналыг хүргүүлсэн. 3. Монгол орны хөдөөгийн иргэдийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадамж болон эрсдэлийн менежментийг боловсронгуй болгох нь буюу Адапт төсөлд Улаанбаатар хот болон 21 аймгийн хэмжээнд Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааны суурь судалгааг хамтран хийх талаар санал хүргүүлсэн боловч санхүүжилт авч чадаагүй. 4. БНХАУ-ын Өвөрмонголын Цаг агаарт зориудаар нөлөөлөх төвийн Билгээгийн багтай хамтран Хуурайшилттай тэмцэх зорилготой хил орчмын бүсэд хамтарсан судалгааны ажлын төслийн саналд хамтарч ажиллах саналыг хүргүүлсэн, БНХАУ талаас санхүүжилт авч чадсан эсэх талаар шийдвэрийг хүлээж байна.</p>	100
20	<p><b>Арга хэмжээ-2.6</b> ЦАЗН Сургалт, сурталчилгаа</p>	Улсын төсөв	Тодорхой бүлгүүдэд сургалт, илтгэл зохион	2	3-аас дээш	<p>1.Тайландын Хаант Улсын "Хааны бороо" багийхантай хамтран Өмнөговь аймагт 2025 оны 06 сарын 23-26-ны өдрүүдэд 2 талт хамтын ажиллагааны уулзалтыг</p>	

			байгуулсан тоо		<p>гадаад харилцааны хэлтэстэй хамтран зохион байгуулсан.</p> <p>2. 2025 оны 10 сарын 02-04-ний өдрүүдэд Өмнөговь аймагт болсон “Цөлжилтийн эсрэг-Ногоон ирээдүй” олон улсын эрдэм шинжилгээний бага хуралд оролцон Өмнөговь аймгийн ус цаг уурын төвтэй хамтран ЦАЗН үйл ажиллагаагаа ард иргэдэд танилцуулаж, сурталчилгаа хийж, мэдээлэл, мэдлэг түгээсэн.</p> <p>3. 2025 оны 10 сарын 16-ны өдөр Монгол улс, БНХАУ-ын Цаг уурын байгууллага хоорондын “Цаг уурын шинжлэх ухаан, технологийн салбарт хамтран ажиллах” хоёр талт хамтын ажиллагааны 18 дугаар уулзалтад “Weather modification activities in Mongolia” сэдвээр танилцуулах илтгэл тависан.</p> <p>4. 2025 оны 10 сарын 22-ны өдөр Монгол улсын их сургуулийн Ус Цаг уурын тэнхимийн оюутнуудад “Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагаа” нэртэй танилцуулах хичээл орсон.</p> <p>5. 2025 оны 09 сарын 30-нд “Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааны үр нөлөөг сайжруулах нь” сэдэвт уулзалтыг ахмадын зөвлөлтэй хамтран зохион байгуулсан. Уг үйл ажиллагаанд 21 аймгийн ЦАЗН хариуцсан албан хаагч нар онлайнаар оролцсон.</p>	100
<b>Бүгд</b>						<b>100</b>

Тайлагнасан:

Нэгжийн дарга

ТЕХНОЛОГИ, ИННОВАЦЫН ХЭЛТСИЙН ДАРГА



/Д. БАТДОРЖ/

**2025-12-15**

ОГНОО

**АРХИВ, МЭДЭЭЛЛИЙН САНГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА  
Д.БАТДОРЖИЙН 2025 ОНЫ ЖИЛИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ,  
ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС**

Байгууллагын нэр: ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР  
Нэгжийн нэр: АРХИВ, МЭДЭЭЛЛИЙН САНГИЙН ХЭЛТЭС

**1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

№	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ	Гүйцэт-гэлийн түвшин	Нийт (70 оноо)
<b>1</b>	<b>2</b>	<b>3</b>	<b>4</b>
	<b>Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт</b>	<b>96.9</b>	<b>67.8</b>

**2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний биелэлтийн хувь	Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 оноо)
<b>1</b>	<b>2</b>	<b>3</b>	<b>4</b>
1	Арга хэмжээ №1. Зүүн хойд Азийн хүчиллэг тунадасны сүлжээ (EANET)-ний газраас зохион байгуулсан Шар шороон шуурганы ажиглалтад Хиймэл дагуулын хяналтыг ашиглах нь. Цахим сургалтад оролцсон. 2025-12-13	100	
2	Арга хэмжээ №2. ДЦУБ-аас зохион байгуулсан ClimSA төслийн хүрээнд ДЦУБ-ын Үйлчилгээний газраас зохион байгуулсан Уур амьсгалын үйлчилгээний үндэсний (NFCS) хүрээний ашиг тусын талаарх техникийн семинар. Цахим сургалтад оролцсон. 2025-12-09	100	
3	Арга хэмжээ №3. ДЦУБ-аас зохион байгуулсан Уур амьсгалын үйлчилгээний Тусламжийн төв байгуулах (HD4CS). Цахим сургалтад оролцсон. 2025-12-15	100	
4	Арга хэмжээ №4 ЦУОШГазрын Ёс зүйн дэд хорооноос зохион байгуулсан "Сэтгэцийн эрүүл мэнд ба Ёс зүй, Стресс менежмент" сургалтад оролсон. 2025-11-19		
5	Арга хэмжээ №5. Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэх Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн шинэчлэгдсэн зорилт, арга хэмжээ чуулганд оролцсон, БОУАӨЯ, GIZ, UNDP, ADB, FAO, UNICEF, Шангри-Ла, 2025-11-05	100	
6	Арга хэмжээ №6. ДЦУБ-аас зохион байгуулсан ДЦУБ-ын 2028-2031 оны Стратегийн төлөвлөгөөний талаархи Зүүн ба Зүүн Өмнөд Азийн дэд бүсийн семинар. Цахим сургалт. 2025-09-15	100	

7	Арга хэмжээ №7. УЦУОХШХ-ийн шинэчилсэн найруулга боловсруулах дэд болон үндсэн ажлын хэсгийн ажилд оролцсон. 2025-07...10сар	100	
8	Арга хэмжээ №8. Архивын ерөнхий газар болон Монгол улсын Ерөнхий прокурорын газраас хамтран зохион байгуулсан “Зөрчлийн бүртгэл мэдээллийн нэгдсэн сан” сургалтад 2025-05.27-нд хамрагдсан.	100	
9	Арга хэмжээ №9. Нийгмийн даатгалын ерөнхий газраас зохион байгуулсан “Нийгмийн даатгалын багц хууль” сургалтад 2025-05.02-нд хамрагдсан.	100	
10	Арга хэмжээ №10. БОУАӨЯамнаас зохион байгуулсан “Тусгай хамгаалалтай газар нутгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн танилцуулга” сургалт өдөрлөгт 2025-04-21-нд хамрагдсан.	100	
11	Арга хэмжээ №11. Авлигатай тэмцэх газар, ЦУОШГ-ын Ёс зүйн дэд хорооноос хамтран зохион байгуулсан “Авлига үүсэхэд нөлөөлдөг хүчин зүйл, шалтгаан,нөхцөл” сэдэвт сургалтад 2025-04-17нд хамрагдсан.	100	
12	Арга хэмжээ №12. Байгууллагад “Microsoft 365” ашиглах болсонтой холбоотой “Microsoft 365 -ын хэрэглээ” сургалтад 2025-04.04-нд хамрагдсан.	100	
13	Арга хэмжээ №13. ЦУОШГ-ын Ёс зүйн дэд хорооноос зохион байгуулсан Монгол улсын Ёс зүйн хорооны гишүүн Доктор М.Цэрэнбатын “Төрийн албан хаагчийн ёс зүй” сэдэвт сургалтад 2025-02-18 нд хамрагдсан.	100	
14	Арга хэмжээ №14. ISO9001:2015 Чанарын менежментийн тогтолцооны стандарт авах цуврал сургалтад 2025-01-01-ээс 2025-04-30 хооронд 7 хоног бүрийн 3 дах өдөр Ажлын хэсгийн гишүүдийн хамт хамрагдсан. Ажлын хэсгийн ахлагчаар ажиллаж байна.	100	
<b>Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний дундаж оноо</b>			

### 3. Хандлага, ёс зүй, урчадварын үнэлгээ

№	Хандлага, ёс зүй, ур чадвар	Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 оноо)
1	2	4
1.	Хандлага, ёс зүй	
2.	Удирдан зохион байгуулах	
3.	Асуудал шийдвэрлэх	
4.	Манлайлах	
5.	Багаар ажиллах	
6.	Харилцаа	

Ур чадварын үзүүлэлт(ажлын онцлогоос хамаарсан)	
1.	Мэргэжлийн ур чадвар №1.
2.	Мэргэжлийн ур чадвар №2.
<b>Дундаж оноо</b>	

**4. Гүйцэтгэлий үнэлгээ**

1.	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт ( <i>Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт</i> )	<b>67.8</b>
2.	Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт (Төсвийн шууд захирагчийн үнэлгээ)	.....
3.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Төсвийн шууд захирагчийн үнэлгээ)	.....
4.	Үнэлгээний оноод орсон өөрчлөлт (Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих )	..... ОНОО
<b>Нийт оноо =</b> (Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо) – Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо		<b>86.7</b>

**Үнэлгээ өгсөн:**

Цаг уур, орчны шинжилгээний газрын дарга

(албан тушаал)

**Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:**

Технологи, инновацын хэлтсийн дарга..... /Д.Батдорж/

(албан тушаал)

**Төсвийн шууд захирагч**

(гарын үсэг)

(огноо)

/Э. Баттулга/

**Нэгжийн дарга:**

(гарын үсэг)

(огноо)